



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/89/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261685 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Энхжин
Утас: 261685 Цахим хаяг: enkhjinb@audit.gov.mn
Аудитыг гэрээр гүйцэтгэсэн:
Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК -ийн
Захирал Д. Баатарсайхан
Утас: 99099119
Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	9
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	9
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
8. Аудитын илрүүлэлт	13
8.1 Залруулсан алдаа	13
8.1 Зөвлөмж	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ
СИСТЕМ ТӨХК-ийн ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ОТГОНБААТАР ТАНАА

2022.03.15 № 04/584
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

"Чойбалсангийн ДЦС-ын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт шинэ станцаар өргөтгөх" төслийн ажлын зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх ЭХА-012/2019 тоот гэрээг 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдөр гүйцэтгэгч компани болох БНХАУ-ын ТБЕА ХХК-тай байгуулсан байна. Төслийн нийт санхүүжилт 79.0 сая ам.доллар ба үүний 60.0 сая ам.долларыг МУ-ын Хөгжлийн банкны зээлээр, 19.0 сая ам.долларыг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх ба 2021 онд улсын төсвөөс 6,000.0 сая төгрөг, МУ-ын хөгжлийн банкнаас 19,771.6 сая төгрөгийн зээлийг авч гүйцэтгэгч компанид тус тус олгосон байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Эрчим хүчний сайдын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн а/12 дугаар тушаалаар тус компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд нийт орлогыг 49,435.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 49,220.9 сая төгрөгөөр, ашгийг 215.0 сая төгрөг байхаар баталсан байна.

Эрчим хүчний сайдын 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн а/125 дугаар тушаалаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 6,686.8 сая төгрөг болгон тодотгосон байна. Гүйцэтгэлээр 51,828.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 51,093.7 сая төгрөгийн зардал гарган, 688.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь 2021 онд зорилтот бүлгийн хүрээнд 18 арга хэмжээ төлөвлөснөөс 83.3 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	93,419,462.61	662,506,965.47
1.1.2	Дансны авлага	234,956,391.26	454,618,908.30
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	760,158.61	784,600,264.36
1.1.4	Бусад авлага	860,512,668.03	1,583,237,007.74
1.1.6	Бараа материал	1,969,651,638.58	1,614,529,701.67
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	16,941,407.37	6,015,198,040.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	147,989,000.00	164,843,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,324,230,726.46	11,279,533,887.54
1.2.1	Үндсэн хөрөнгө	76,716,657,566.17	94,813,319,760.35
1.2.2	Биет бус хөрөнгө	18,356,644,760.08	18,338,606,034.16
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	479,638,462.31	
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	95,552,940,788.56	113,151,925,794.51
1.30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	98,877,171,515.02	124,431,459,682.05
2.1.1.1	Дансны өглөг	2,602,611,179.05	2,226,499,990.68
2.1.1.2	Цалингийн өглөг	34,217,999.49	119,710,156.86
2.1.1.3	Татварын өр	432,945,733.32	389,643,001.25
2.1.1.4	НДШ-ийн өглөг	9,229,993.80	125,837,601.89
2.1.1.6	Хүүний өглөг	0	268,649,432.58
2.1.1.8	Урьдчилж олсон орлого	626,897,905.75	150,078,877.65
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,705,902,811.41	3,280,419,060.91
2.1.2.1	Урт хугацаат зээл	8,133,831,592.95	27,115,990,130.23
2.1.2.5	Хойшлогдсон орлого	4,562,281,701.20	10,360,126,605.18
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	12,696,113,294.15	37,476,116,735.41
2.20	Өр төлбөрийн нийт дүн	16,402,016,105.56	40,756,535,796.32
2.3.1	Өмч: -төрийн	48,102,825,726.66	50,825,627,452.43
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,295,907,268.04	11,245,314,869.70
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	21,022,232,225.77	18,844,022,560.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,054,190,188.99	2,759,959,003.60
2.3.11	Эздийн өмчийн дүн	82,475,155,409.46	83,674,923,885.73
2.40	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	98,877,171,515.02	124,431,459,682.05

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12 -р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	46,244,019,716.62	50,422,702,203.37
2	Борлуулалтын өртөг	32,571,646,699.38	36,179,438,405.42
3	Нийт ашиг/алдагдал/	13,672,373,017.24	14,243,263,797.95
4	Түрээсийн орлого	32,853,894.28	31,838,270.15
5	Хүүний орлого	19,988,187.35	828,347.88
6	Бусад орлого	969,153,877.86	1,372,879,616.57
7	Борлуулалт, маркетингийн зардал	10,217,342,581.98	9,783,257,689.58
8	Ерөнхий ба удирдлагын зардал	2,311,994,052.22	2,110,462,508.87
9	Санхүүгийн зардал	84,367,367.35	78,853,776.98
10	Бусад зардал	1,683,765,166.67	2,882,973,803.96
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(74,573,965.61)	(58,700,795.15)
12	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	322,325,842.90	734,561,458.01
13	Орлогын татварын зардал	19,879,920.23	46,176,322.52
14	Татварын дараах ашиг (алдагдал)	302,445,922.67	688,385,135.49
15	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	302,445,922.67	688,385,135.49
16	Орлогын нийт дүн	302,445,922.67	688,385,135.49
17	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл	66,306,982,543.66	11,313,831,331.75	95,273,683.00	1,733,820,202.61	79,449,907,761.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	(18,299,430,500.00)		18,299,430,500.00		0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				302,445,922.67	366,601,348.21
Өмчид гарсан өөрчлөлт	95,273,683.00		2,627,528,042.77		2,722,801,725.77
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(17,924,063.71)		17,924,063.71	0.00
2020 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл	48,102,825,726.66	11,295,907,268.04	21,022,232,225.77	2,054,190,188.99	82,475,155,409.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				12,158,169.18	12,158,169.18
Залруулсан үлдэгдэл				2,066,348,358.17	2,066,348,358.17
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				688,385,135.49	688,385,135.49
Бусад дэлгэрэнгүй орлого					0.00
Өмчид гарсан өөрчлөлт	2,722,801,725.77		(2,178,209,665.77)		544,592,060.00
Зарласан ногдол ашиг				(45,366,888.40)	(45,366,888.40)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(50,592,398.34)		50,592,398.34	0.00
2021 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл	50,825,627,452.43	11,245,314,869.70	18,844,022,560.00	2,759,959,003.60	83,674,923,885.73

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1.	Мөнгөн орлогын дүн (+)	50,769,135,685.09	49,169,630,695.60
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	49,653,117,322.47	48,137,670,134.35
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	109,740,331.00	46,569,378.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,006,278,031.62	985,391,183.25
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	44,282,475,297.59	43,357,174,984.77
1.2.1	Ажилчдад төлсөн	12,479,745,143.19	12,090,619,268.64
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,801,404,000.07	3,728,776,064.29
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	11,036,766,829.20	13,223,798,887.30
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	33,891,036.92	41,106,392.07
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,011,339,585.93	9,476,351,090.05
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	84,367,367.35	78,853,776.98
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	4,448,081,580.23	3,980,279,619.15
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	168,903,789.00	94,714,710.08
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,217,975,965.70	642,675,176.21
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,486,660,387.50	5,812,455,710.83
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	34,258,187.35	5,498,847.88
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	14,270,000.00	4,670,500.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	19,988,187.35	828,347.88
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,206,754,802.82	24,138,788,875.94
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	6,179,463,121.00	4,405,150,504.70
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	27,291,681.82	8,950,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө		19,724,688,371.24
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(6,172,496,615.47)	(24,133,290,028.06)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,819,825.97	19,724,688,388.61
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		19,724,688,371.24
3.1.4	Валютын ханшийн ашиг	4,819,825.97	17.37
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	368,370,297.24	834,766,568.52
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	346,070,147.74	766,618,295.22
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	22,300,149.50	22,781,384.90
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	45,366,888.40
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний	(363,550,471.27)	18,889,921,820.09
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(49,386,699.24)	569,087,502.86
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	142,806,161.85	93,419,462.61
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	93,419,462.61	662,506,965.47

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он			
				төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Боловсруулсан ЦЭХ	мян. кВтц	234,000.0	233,475.0	245,595.8	12,120.8	105.2
2	Нийт түгээх ЦЭХ	мян. кВтц	256,000.0	261,030.3	281,637.1	20,606.8	107.9
	Түгээх ЦЭХ	мян. кВтц	201,000.4	201,105.0	211,959.9	10,854.9	105.4
	ДҮТ-ХАЦЭХ	мян. кВтц	54,000.3	59,670.0	69,474.8	9,804.8	116.4
	Импортын ЦЭХ	мян. кВтц	260.3	255.3	202.3	(53.0)	79.2
3	Түгээлт ДЭХ	мян. Гкал	312.1	302,400.0	322,812.0	20,412.0	106.8
4	Дотоод хэрэглээний цахилгаан эрчим хүч	хувь	0.1	0.1	0.1	(0.0)	98.8
5	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал	хувь	0.1	0.1	0.1	(0.0)	66.7
6	Нийт орлого	мян.төг	47,292,600.0	49,435,852.5	51,828,248.4	2,392,395.9	104.8
	Үүнээс: Борлуулалтын орлого	мян.төг	46,244,000.0	47,968,600.0	50,422,702.2	2,454,102.2	105.1
	Бусад орлого	мян.төг	822,000.3	606,012.5	1,101,467.4	495,454.9	181.8
	50 мВт ТХН-ийн орлого	мян.төг	226,000.3	861,240.0	304,078.8	(557,161.2)	35.3
7	Нийт зардал	мян.төг	46,970.3	49,220,839.0	51,093,687.0	1,872,848.0	103.8
	Үүнээс : Удирдлагын зардал	мян.төг	318,600.0	327,548.8	323,242.3	(4,306.5)	98.7
	50 мВт ТХН-ийн зардал	мян.төг	290,400.0	861,240.0	663,336.0	(197,904.0)	77.0
8	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	322,300.0	215,013.5	734,561.5	519,548.0	341.6
	ААНОАТатвар	мян.төг	19,000.9	-	46,176.3	46,176.3	-
9	Цэвэр ашиг /алдагдал /	мян.төг	302,000.4	215,013.5	688,385.1	473,371.6	320.2
10	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	-	-	45,366.9	45,366.9	-
11	БО-ын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.0	1.0	1.0	(0.0)	99.0
12	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	мян.төг	6,265,000.8	6,686,767.6	4,414,100.5	(2,272,667.1)	66.0
13	Түлшний хувийн зарцуулалт ЦЭХ	гр/кВтц	632.9	641.8	640.6	(1.1)	99.8
	ДЭХ	кг/Гкал	192.0	193.0	192.1	(0.9)	99.5
14	Нийт ааллага	мян.төг	1,384,000.8	77,000.0	2,822,456.2	2,745,456.2	3,665.5
15	Нийт өглөг	мян.төг	11,785,000.3	9,797,400.0	30,396,409.2	20,599,009.2	310.2
	Богино хугацаат өглөг	мян.төг	3,651,000.5	2,450,000.0	3,280,419.1	830,419.1	133.9
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	8,133,000.8	7,347,400.0	27,115,990.1	19,768,590.1	369.1
16	Нийт ажиллагсдын тоо	тоо	623	620	626	6.0	101.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж, аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөхөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулах, ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-аас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа гүйцэтгэж, хяналтыг захирал Д.Баатарсайхан хэрэгжүүлсэн.

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 1/924 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Тус байгууллага нь Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулах нийтлэг журам”, Гүйцэтгэх захирлын баталсан “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ын дагуу хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Хяналт шалгалтаар санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой барилга байгууламжийн хийц хэсгийн элементээрх задаргааны дагуу их засварын зардлыг капиталжуулах, элэгдлийг тооцож, санхүүгийн тайланд тусгах, цаг ашиглалт, төрөөс хариуцах цахилгаан дулааны хөнгөлөлт, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, их засвар гэсэн чиглэлүүдийг хамруулсан байна.

Иймд компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авах дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 49,688.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 496.9 сая төгрөгөөр тогтоов.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн зорилго нь хэрэглэгчийн хэрэгцээт цахилгаан, дулааны эрчим хүчийг үйлдвэрлэн хэвийн найдвартай хангахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаа, дулаан үйлдвэрлэл, түгээлт хослон эрхлэх үйл ажиллагаа гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хувьцаат компани статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс Эрчим хүчний яам 70.0 хувь, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 30.0 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийг Засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 164 дугаар “Эрчим хүчний салбарын төрийн өмчит үйлдвэрийн газруудад бүтэцийн өөрчлөлт хийх тухай” тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.7 дахь заалттай нийцэж байна.

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг сар бүр 0.7 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон

өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. КОВИД-19 цар тахалтай холбоотой улсын хэмжээнд тогтоосон хөл хорио, хил, гаалийн асуудлаас шалтгаалан урсгал засвар, их засвар, хөрөнгө оруулалтын ажлууд хойшлогдсон ч өөрсдийн дотоод нөөц боломжоор бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ давуулан биелүүлж ажилласан.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулаагүй, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоож ажиллаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	93,419.5	662,507.0	569,087.5
БХХО			-
Авлага	1,244,218.2	2,987,299.2	1,743,081.0
Урьдчилгаа	16,941.4	6,015,198.0	5,998,256.6
Бараа материал	1,969,651.6	1,614,529.7	(355,121.9)
Үндсэн хөрөнгө	77,196,296.0	94,813,319.8	17,617,023.7
Биет бус хөрөнгө	18,356,644.8	18,338,606.0	(18,038.7)
Нийт хөрөнгийн дүн	98,877,171.5	124,431,459.7	25,554,288.1
Өр төлбөрийн дүн			-
Богино хугацаат өглөг	3,705,902.8	3,280,419.1	(425,483.8)
Урт хугацаат өглөг	12,696,113.3	37,476,116.7	24,780,003.4
Эздийн өмч	82,475,155.4	83,674,923.9	1,199,768.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	98,877,171.5	124,431,459.7	25,554,288.1

Касс дахь бэлэн мөнгө 6.3 сая, арилжааны банкны харилцах дансанд 656.2 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд НӨАТ-ын авлага 4.3 сая, НДШ-ийн авлага 0.04 сая, хойшлогдсон НӨАТ-ын тооцоо 780.2 сая, бусад авлага 2,037.9 сая төгрөг байна.

Тайлант онд ковид-19 цар тахалтай холбоотойгоор айл өрх, аж ахуй нэгж байгууллагын цахилгаан дулааны эрчим хүчийг төрөөс хариуцах хүрээнд үүссэн Эрдэнэт үйлдвэрээс авах авлага 1,268.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Хугацаандаа байгаа 2,822.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна.

Урьдчилгаа данс тайлант онд их засвар болон гэрээт ажлын төлбөр 999.2 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн дүнгээр нэмэгдсэн шилжүүлсэн байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 онд урьдчилгаа шилжүүлсэн 16.9 сая төгрөгийн ажил Ковид-19 цар тахлын шалтгаанаас дуусаагүй, гүйцэтгэлийг хүлээн аваагүй байна. Тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 1,000.9 сая төгрөгийг их засвар болон холбогдох зардлын дансанд шилжүүлэн бүртгэсэн байна. Мөн улсын төсвөөс төслийн нэгжид 6,000.0 сая төгрөг урьдчилж орсон байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,614.5 сая төгрөг болж, 355.1 сая төгрөгөөр буурсан нь үндсэн үйлдвэрлэлтэй холбоотой мазут, цахилгааны сэлбэг, зуухны сэлбэг, төмөр зэрэг эхний үлдэгдэлтэй материалуудаас зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 431.7 сая, дуусаагүй барилга, их засварын зардал 25,118.7 сая, ТӨБЗГ-ын 2021 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 431 тоот хөрөнгө шилжүүлэх тогтоолыг үндэслэн Дорнод аймгийн Дашбалбар сумын өмчийн газрын балансаас баланст шилжүүлэн авсан 573.8 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны А-2/1390 дугаар албан бичиг, 584 дугаар тогтоолоор 1,535.8 сая төгрөгийн акталсан дүнгээр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 497.6 сая төгрөгийн программ хангамжийн хорогдлын дүнгээр буурчээ.

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 164.8 сая төгрөг болж 16.8 сая төгрөгөөр өссөн нь малын нас дэвшилт, төлийн орлоготой холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр 3,280.4 сая төгрөгийн 1,624.2 сая төгрөг нь төвийн бүсээс худалдан авсан цахилгаан эрчим хүчний төлбөр, 328.8 сая төгрөг нь нүүрсний төлбөр, 253.8 сая төгрөг нь 2021 онд хийгдсэн их засвар, ТЗБАХ-ны засварын ажлын баталгаат засварын барьцаа төлбөр, 299.1 сая төгрөг нь НӨАТ-ын өр, 49.7 сая төгрөг нь ААНОАТ-ын өр, 40.8 сая төгрөг нь ХХОАТ-ын өр, 125.8 сая төгрөг нь төслийн нэгжийн НДШ-ийн өр, 119.7 сая төгрөг нь төслийн нэгжийн ажилтнуудын цалингийн өр, 268.6 сая төгрөг нь МУ-ын хөгжлийн банкнаас авсан зээлийн хуримтлагдсан хүүгийн өр, 150.1 сая төгрөг нь урьдчилж орсон орлого, 19.7 сая төгрөг нь бусад бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өр төлбөр тус тус байна.

Урьдчилж орсон орлого 150.1 сая төгрөгийн 4.8 сая төгрөг нь Цайрт минерал ХХК, 4.0 сая төгрөг нь Түүх соёл ХХК, 99.0 сая төгрөг нь Эм эл цахиурт овоо ХХК-уудын цахилгаан эрчим хүчний барьцаа төлбөрийн үлдэгдэл, 12.4 сая төгрөг нь Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв ХХК-ийн гэрээт ажлын төлбөрийн урьдчилгаа, 8.3 сая төгрөг нь Сүхбаатар аймгийн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний илүү төлөлт, 21.8 сая төгрөг нь Дорнод аймгийн хэрэглэгчдийн цахилгаан, дулааны эрчим хүчний илүү төлсөн төлбөрүүд тус тус байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 2004 онд эрчим хүчний алдагдал бууруулах төсөл хэрэгжсэнээс үүссэн 7,953.4 сая төгрөгийн өр төлбөрөөс 766.6 сая төгрөг төлөгдсөн байна. Тайлант онд Хөгжлийн банкнаас "Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт шинэ станцаар өргөтгөх" төслийн хүрээнд 19,771.6 сая төгрөгийн зээл авч, гүйцэтгэгч компани БНХАУ-ын "ТБЕА" ХХК-д ажлын гүйцэтгэлийн санхүүжилтэд ба зээлийн хуримтлагдсан хүүгийн төлбөр 268.7 сая төгрөг, зээлийн үлдэгдэл 19,771.6 сая төгрөг байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Нийт зардал өмнөх онтой харьцуулахад 558,078.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэн, нүүрсний үнийн өсөлт, төвийн бүсээс худалдан авах цахилгаан эрчим хүчний хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт цахилгаан эрчим хүч, дулаантай холбоотой шууд болон шууд бус материал, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлуудыг хамруулсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн а/12 дугаар тушаалаар тус компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд нийт орлогыг 49,435.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 49,220.9 сая төгрөгөөр, 215.0 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна.

Эрчим хүчний сайдын 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн а/125 дугаар тушаалаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 6,686.8 сая төгрөг болгон тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 51,828.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 51,093.7 сая төгрөгийн зардал гарган, 688.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 51,828.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 2,392.4 сая төгрөг буюу 4.8 хувиар давсан нь цахилгаан дулааны эрчим хүчний хэрэглээний өсөлт нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 51,093.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,872.8 сая төгрөг буюу 3.8 хувиар илүү гүйцэтгэлтэй байгаа нь цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлттэй холбоотойгоор худалдан авсан цахилгаан эрчим хүчний өртгөөс шалтгаалжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 49 арга хэмжээнд өөрийн эх үүсвэрээс 4,414.10 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 688.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 473.4 сая төгрөгөөр илүү байгаа нь борлуулалтын орлого төлөвлөснөөс 2,454.1 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

ТӨБЗГ-ын 2021 оны 04 тоот шийдвэрийн дагуу тайлант онд ашгийн 15.0 хувь буюу 45.4 сая төгрөгийн ногдол ашиг, түрээсийн орлогын 40.0 хувь буюу 16.9 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Шилэн данс

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 171 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант онд нийт 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 170 ширхэг мэдээллийг хугацаанд нь байршуулж, 1 мэдээлэл буюу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тодотгол хийснээс шалтгаалан дахин байршуулсан байна.

Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 10 сарын 05-ны өдрийн №Б/228 тоот тушаалаар нэр бүхий 40 ажилтанд 22.5 сая төгрөгийн шагнал, "50МВТ төсөл" хэрэгжүүлэх нэгжийн удирдагчийн 2021 оны 06 сарын 25-ны өдрийн №А/04 тоот тушаалаар нэр бүхий 9 ажилтанд 31.3 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. Энэ нь МУ-ын ЗГ-ын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.3 дахь заалттай нийцэхгүй.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газраас тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх Засгийн газрын тогтоолын заалтыг хэрэгжүүлээгүй нь бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 612.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 336.1 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс, 1 албан шаардлага, 3 зөвлөмж бүрэн хэрэгжсэн, Шилэн дансны хуулийг хэрэгжилттэй холбоотой албан шаардлага хэрэгжээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	2	612.5	1	612.5	1	-	50.0
Зөвлөмж	3	336.1	3	336.1			
Нийт дүн	5	948.6	4	948.6	1		50.0

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт шинэ станцаар өргөтгөх төслийн нэгжийн хүрээнд Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-д хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний явцын гүйцэтгэл, гүйцэтгэлээр олгосон санхүүжилт, нягтлан бодох бүртгэлийг шалгана.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 28,703.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 28,518.1 сая төгрөгийн алдааг залруулж, 185.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 185.5 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 496.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул "Зөрчилгүй" дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 28,518.1 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа. Үүнд:

- Цалингийн урьдчилгаа олгохдоо 509.9 сая төгрөгөөр цалингийн өглөг дансыг нэмэгдүүлж дансны бичилт буруу хийсэн.
- Эргэлтийн бус хөрөнгийн ангилалд бүртгэлтэй 24,356.6 сая төгрөгийн барилга байгууламжийг хийц хэсгээр задалж буруу бүртгэсэн.
- Балансаас баланст шилжүүлэн авсан хөрөнгийг бүртгэхдээ 29.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг эздийн өмчийн бусад хэсэг дансыг бууруулж бүртгэсэн.
- Тендерт шалгарсан компанид хамаарах ажлын гүйцэтгэлээр 3,622.4 сая төгрөгийн бараа материалын бүртгэлийг өөрийн санхүүгийн бүртгэлд давхардуулан бүртгэсэн.

8.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Бараа материалын данстай холбоотой асуудалИлрүүлэлт:

Бараа материалын ангилалд бүртгэлтэй туслах аж ахуй болох малын нас дэвшилтийг өртгөөр нь зарлагдаж, 185.5 сая төгрөгийг нийт дүнгээр нь орлого хүлээн зөвшөөрсөн нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 411 тоот тушаалаар баталсан биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний НББ-ын стандартыг мөрдөж ажиллаагүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Малын нас дэвшлийг бүртгэхдээ тухайн малыг данснаас хасаж, буцааж орлого авахгүйгээр нас дэвшлийн үнийн зөрүүгээр орлого хүлээн зөвшөөрөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгуулагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	ДБЭХС ТӨХК	АХГ-2022/89/НА-СТА-ТӨА	Цалингийн урьдчилгаа олгохдоо цалингийн өглөг дансыг нэмэгдүүлж дансны бичилт буруу хийсэн.	Тооцооны дансыг зөв бүртгэх зөвлөмж өгч залруулга хийлгэсэн	1	509,929.1	1	509,929.1						
2	ДБЭХС ТӨХК	АХГ-2022/89/НА-СТА-ТӨА	Тендерт шалгарсан компанид хамаарах ажлын гүйцэтгэлээр бараа материалын бүртгэлийг өөрийн санхүүгийн бүртгэлд давхардуулан бүртгэсэн.	Тооцооны дансыг зөв бүртгэх залруулга өгсөн	1	3,622,405.7	1	3,622,405.7						
3	ДБЭХС ТӨХК	АХГ-2022/89/НА-СТА-ТӨА	Эргэлтийн бус хөрөнгийн ангилалд бүртгэлтэй барилга байгууламжийг хийц хэсгээр задалж буруу бүртгэсэн	Хөрөнгийн ангиллыг зөв хөтлөх зөвлөмж өгч залруулга хийлгэсэн	1	24,356,569.3	1	24,356,569.3						
4	ДБЭХС ТӨХК	АХГ-2022/89/НА-СТА-ТӨА	Бараа материалын ангилалд бүртгэлтэй туслах аж ахуй болох малын нас дэвшилтийг өртгөөр нь зарладагж, нийт дүнгээр нь орлого хүлээн зөвшөөрсөн нь НББНХЗЗ-ыг зөрчиж байна.	Хөрөнгийн ангиллыг зөв хөтлөх зөвлөмж өгч залруулга хийлгэсэн	1	185,462.0							1	185,462.0

5	ДБЭХС ТӨХК	АХГ- 2022/89/НА- СТА-ТӨА	ТӨБЭГ-ын 2021.10.19-ний 431 тоот тогтоолоор хөрөнгө шилжүүлэн авахдаа тус хөрөнгийн хүримтлагдсан элэгдлийг "Эздийн өмчийн бусад хэсэг" дансыг бууруулан буруу бүртгэсэн	Хөрөнгийн ангиллыг зөв хөтлөх зөвлөмж өгч залруулга хийлгэсэн	1	29,183.8	1	29,183.8	-	-	-	1	185,462.0
Дүн													
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал													
1	ДБЭХС ТӨХК	АХГ- 2022/89/НА- СТА-ТӨА	ДБЭХС ХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 10 сарын 06-ны өдрийн №Б/228 тоот тушаалаар нэр бүхий 40 ажилтанд шагнал олгосон байна.	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, хэмнэлттэй ажиллах	1	22,500.0	1	22,500.0					
2	ДБЭХС ТӨХК	АХГ- 2022/89/НА- СТА-ТӨА	ДБЭХС ХК-ийн 50МВТ төсөл хэрэгжүүлэх нэгжийн удирдагчийн 2021 оны 06 сарын 25-ны өдрийн №А/04 тоот тушаалаар нэр бүхий 9 ажилтанд урамшуулал олгосон байна.	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, хэмнэлттэй ажиллах	1	31,358.0	1	31,358.0					
Дүн													
Нийт дүн													
					2	53,858.0				2	53,858.0		
					7	28,767,407.9	4	28,518,087.9		2	53,858.0	1	185,462.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 500/А0150055
АХГ-2022/89/НА-ОА-ТОА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны 10 сарын 05-ны өдрийн Б/228 дугаар тушаалаар нэр бүхий 40 ажилтанд 22.5 сая төгрөгийн шагнал, "50МВт төсөл" хэрэгжүүлэх нэгжийн удирдагчийн 2021 оны 06 сарын 25-ны өдрийн А/04 дугаар тушаалаар нэр бүхий 9 ажилтанд 31.3 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны тогтоолоор баталсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3 "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, хэмнэлттэй ажиллах, аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, ерөнхий нягтлан бодогч Д.Гэрэлчулуун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.БААТАРСАЙХАН

